



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 11459

Арвайхээр



Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Арвайхээр сумын ариутгах татуургын зүүн жигүүрийн шугам сүлжээг тусгай зориулалтын машин механизм ашиглан өндөр даралттай усаар угааж цэвэрлэхэд 15,700,000 (арван таван сая долоон зуун мянга), Арвайхээр сумын 8 дугаар багийн нийтийн орон сууцнуудын халаалтын зуухны сүлжээний насос, хэмжих болон холбох хэрэгсэлд 7,000,000 (долоон сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 22,700,000 (хорин хоёр сая долоон зуун мянга) төгрөгийн зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ О.БАТЖАРГАЛ



011101017